



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар A/373

Мандалговь

Г Агуулахын байршил тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баянжаргалан сумын нутагт орших "Жун Юань" ХХК-ний MV-008652 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг хавсралтаар тогтоосугай.

Хоёр. Тэсрэх материалын агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд хуулийн хугацаанд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүй бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж)-т үүрэг болгосугай.

Гурав. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг мэдээллийн нэгдсэн санд хуулийн хугацаанд бүртгүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т даалгасугай.



488010210



Аймгийн Засаг даргын 2018 оны 09
дүгээр сарын 05-ны
өдрийн 373 дугаар захирамжийн
хавсралт

Тэсрэх материалын агуулахын байнгын байршлын солбилцол

| Цэгийн дугаар | X | Y |
|---------------|----------------|-----------------|
| 1. | 45° 46' 56,54" | 107° 56' 42,40" |
| 2. | 45° 46' 56,65" | 107° 56' 38,42" |
| 3. | 45° 46' 59,84" | 107° 56' 38,58" |
| 4. | 45° 46' 59,74" | 107° 56' 42,56" |